



ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: ХААИС-ийн Магистр, докторын сургууль

Хөтөлбөрийн нэр: Ургамлын нөөц биоүйлдвэрлэл

Индекс: 081114 Магистр

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Оюунцэцэг (Ph.D).

Гишүүд: Ц.Энхтуул (Ph.D)

О.Мөнхзул (M.Sc).

Улаанбаатар хот
2023 он

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр	ХААИС-ийн Магистр, докторын сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр	Ургамлын нөөц биоүйлдвэрлэл	
Индекс	E081114	
Шинжээчид	<p>Ахлагч: Б. Оюунцэцэг. Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургууль, Биологийн тэнхимийн багш, доктор, профессор</p> <p>Гишүүд: Ц.Энхтуул- ШУТИС, Үйлдвэрлэлийн Технологийн Сургууль, Биотехнологи шим тэжээлийн салбарын профессор, доктор</p> <p>О.Мөнхзул- Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний дэд ажилтан, магистр</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч П.Оргилмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.02.09	Шинжээчийн багтай гэрээ байгуулах
	2023.02.09	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах
	2023.02.12	Өөрийн үнэлгээний тайланг уншиж судлан дүгнэлт хийх, тодруулах асуудал бүхий урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид илгээх
	2023.02.13, 14	Шинжээчийн баг сургууль дээр ажиллах
	2023.02.17	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт, тайланг илгээх.
	2023.03.09	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2022.03.10	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.03.12	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн нэр: “Ургамлын нөөц, био-үйлдвэрлэл”

Индекс: E 081114

Монгол Улсын хэмжээнд байгалийн ургамлыг тодорхойлох, түүний тархац, нөөцийг тооцох, зөв зохистой ашиглах, тарималжуулах замаар био-үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлын хүрээнд ургамлын мэргэжилтэн дутагдалтайг анхаарч Гэгээрлийн сайдын 2001.03.18-ны өдрийн №130 тоот тушаалаар Хөдөө аж ахуй их сургуульд Ургамлын нөөц био-үйлдвэрлэл магистрын хөтөлбөрийг (индекс E620400) анх нээж, элсэлтээ авч албан ёсоор сургалтаа эхлүүлсэн бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын БСШУ-ны Сайдын 2014 оны “Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” А/370 тоот, БСШУ-ны сайдын 2017 оны 6-р сарын 29-ний өдрийн А/52 дугаар тушаалын дагуу Хөдөө аж ахуй гэсэн төрөлжсөн чиглэлд батлуулан сургалтын үйл ажиллагааг явуулж байгаад 2022 оноос БШУ-ы сайдын 2022.05.09-ний өдрийн А/160 дугаар тушаалын дагуу 0811114 индекстэй, 0811 Газар тариалан ба Мал аж ахуй нарийвчилсан чиглэлийг мөрдөж сургалтын хөтөлбөрийг шинэчлээд байна.

Тус хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг удаа дараа тухайлбал, Агроэкологийн сургуулийн хөтөлбөрийн хороогоор 2014.09.15-ны өдөр хэлэлцүүлэн ХААИС-ийн захирлын 2015.06.26-ны өдрийн А/219 тоот тушаалаар шинэчлэн батлуулж, дараа нь 2021 онд тус хөтөлбөрт 40% шинэчилсэн боловсруулалт хийж, 2021.03.18-ны өдөр бүрэлдэхүүн сургуулийн Хүрээлэн буй орчин судлалын хөтөлбөрийн хороогоор, 2021.04.01-нд Агроэкологийн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн сайжруулж, хамгийн сүүлд ХААИС-ийн ректорын тушаалаар 2021.08.27-нд шинэчлэн батлуулсан.

Монгол Улсад дээд боловсролын системд олон улсын жишгийг дагаж их, дээд сургуулиудын мэргэжлийн хөтөлбөрүүд бүхэлдээ шаталсан сургалтад шилжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ургамлын нөөц, био-үйлдвэрлэл хөтөлбөр нь 2001 онд анх нээгдэж, 2004 оноос шаталсан сургалт явуулж магистрын хөтөлбөрөөр элсэлт авч эхэлсэн.

2004-2022 онд Ургамлын нөөц, био-үйлдвэрлэл мэргэжлээр нийт 29 магистр төгсөж, Монгол Улсын Газар тариалангийн шинжлэх ухаан-сургалт-үйлдвэрлэлийн салбарт амжилттай ажиллаж байна.

Ургамлын нөөц, био-үйлдвэрлэлийн магистрын сургалтын төлөвлөгөө нь Агроэкологийн сургуулийн хөтөлбөрийн хороогоор 2021.03.18-ны өдөр, Эрдмийн зөвлөлөөр 2021.04.01-ний өдөр тус тус хэлэлцэгдэж батлагдсан.

Хөтөлбөрийн зорилго

Ургамлын нөөц, биоүйлдвэрлэл магистрын хөтөлбөрийн стратеги төлөвлөгөөний эрхэм зорилго нь ургамлын нөөц судлалын өвөрмөц мэдлэг-инновацид суурилсан "судалгаа-үйлдвэрлэл"-ийг хөгжүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Судлаачийн ёс зүйг эрхэмлэдэг, судалгааны ажлыг бие даан төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах, мэдээлэх арга зарчмыг эзэмшсэн дотоод, гадаадад өрсөлдөх чадвартай ургамал судлалаар мэргэшсэн судлаачдыг бэлтгэх,
2. Ургамлын аймаг, ургамалжил, байгалийн ургамлын нөөц тооцох судалгааны арга зүйд суралцсан, биологийн төрөл, зүйл хамгааллын мэдлэгтэй, ургамлан нөмрөгийг хамгаалах, нөхөн сэргээх, зөв зохистой ашиглах мэдлэг, чадвар, дадалтай ургамал судлаач бэлтгэх,
3. Биоүйлдвэрлэлийн аргаар нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын нөөцийг нэмэгдүүлэх аргыг эзэмшсэн ургамлын нөөц биоүйлдвэрлэлийн судалгааны магистр бэлтгэх.

Хамрах хүрээ: Газар тариалан, мал аж ахуй

Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Монгол орны нийгэм эдийн засаг, байгаль орчинд тулгамдсан уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, бэлчээрийн талхлагдал, газрын доройтол, биологийн төрөл,

зүйлийн ховордолт, уурхайн улмаас эвдэрсэн газар, шар шороон шуурга, цөлжилт зэрэг асуудлыг шийдвэрлэх ургамлын нөөц үйлдвэрлэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэдэг хөтөлбөр зайлшгүй шаардлагатай болсон. Иймээс 2004 оноос эхлэн Ургамлын нөөц, био-үйлдвэрлэлийн хөтөлбөрийг шаталсан сургалтанд шилжүүлж сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан сайжруулж ирсэн.

Ургамлын нөөц био-үйлдвэрлэл магистрын хөтөлбөр нь суралцагсад Монгол орны ургамлын аймгийн төрөл зүйлийн нөөцийг тооцож, түүнийг тарималжуулах, ургамалжуулах замаар нэмэгдүүлэх, байгалийн ургамлын тарьмал нөөцөөр малын тэжээл бэлтгэл, ургамлын гаралтай эмийн түүхий эд, гоо сайхны бүтээгдэхүүн болон нөхөн сэргээлтийн зориулалтаар тарих үр, тарьц суулгацыг үйлдвэрлэн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн онол арга зүй био үйлдвэрлэлийн мэдлэг, чадвар, дадал олгодог.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна

1.1 Хөтөлбөрийн баримт бичиг

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

1. Монгол улсын ХААИС-ийн дүрэм. ХААИС-ын удирдах зөвлөлийн 2019.04.25-ны өдрийн 2 тоот тушаал.
2. Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам. 2022.07.05-ны өдрийн А/194 журам.
3. ХААИС-ийн сургалтын журмыг шинэчлэн батлах. 2022.07.05-ны өдрийн А/194 журам.
4. ХААИС-ийн магистрант, докторантын гарын авлага. 2022.
5. ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам батлах тухай. 2014.11.14-ний өдрийн А/398 тушаал.
6. Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай. 2014.09.12-ны өдрийн А/370 тушаал.
7. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2007.06.07-ны өдрийн 187 дугаар тушаал.
8. Ахисан түвшинд суралцагчдыг үнэлэх үнэлгээний журам батлах тухай, ХААИС-ийн захирлын 2017.08.31-ний өдрийн А/189 тоот тушаал.
9. Магистр, докторын сургалтын хөтөлбөрийн нэрийн товчлолыг батлах тухай, ХААИС-ийн захирлын 2017.08.31-ний өдрийн А/189 тоот тушаал.
10. ХААИС-ийн магистрант, докторантын эрдэм шинжилгээ, дадлагын багц цаг тооцоход баримтлах журам. А2022.07.05-ны өдрийн А/194 тоот журам.
11. Ургамлын нөөц биоүйлдвэрлэл. Магистрын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар. 2022 он. 199 хуудас
12. “Ургамлын нөөц, биоүйлдвэрлэл” сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажлын хэсэг, ХААИС-ын захирлын 2022.02.15-ны өдрийн А/24 тоот тушаалын гуравдугаар хавсралт.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын хөтөлбөр 5 удаа шинэчлэгдсэн. Хөтөлбөрийн шинэчилэлт хийхдээ ажил олгогч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд суурилдаг.
- Байгалийн ургамлын нөөцийн судалгааг хийж, судалгааны үр дүнд суурилан саван, үнэртэн зэргээр био-үйлдвэрлэл хийхийг зорьж байгаа.
- Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэгт 2 га талбай бүхий ургамал тарималжуулалтын талбайтай.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Магистр докторын сургалтын гарын авлага. 2022 он.
- Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2019.04.25-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн хөгжлийн стратеги төлөвлөгөө”.
- Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2019.04.25-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Их сургуулийн дүрэм”.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бусад тэнхимийн төгсөгчид болон үндсэн төгсөгчдийн эрэлтэд суурилсан 21 төрлийн сонгон судлах хичээлтэй.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн суурь хичээлийн сонголт тааруу.

Зөвлөмж:

- Ургамлын нөөц, био-үйлдвэрлэл гэдэг хөтөлбөр учраас мэргэжлийн заавал судлах 12 багц цаг хичээлд ургамлын ангилалзүй, ургамлын нөөц гэсэн хичээлүүдийг тусгаж өгөх. Энэ нь магистрын түвшний оюутнууд, ажил олгогчдын эрэлтэд суурилсан.
- Магистрт суралцаж байх хугацаанд хамгаалах болзол хангасан эрдэм шинжилгээний ажлын багц цагийг тодруулах. Үүнд: судалгааны аргазүй хэлэлцүүлэхээс гадна Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийг Олон улсын импакт фактор, Web of science, дотоодын эрдэм шинжилгээний бүтээлүүд, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцсон байдлаар ангилан, ялгаатай байдлаар багц цагийг тооцох.

1.3 Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Илрэл нотолгоо:

- Ургамлын нөөц биоүйлдвэрлэл магистрын хөтөлбөрийн сургалтын шинэчилэгдсэн төлөвлөгөө. 2021.08.27-ны өдрийн Б/183 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (Тус хөтөлбөр нь нийт 5 удаа шинэчилэгдсэн),
- “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, БСШУ-ны сайдын 2014.09.12–ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралт,
- “ХААИС-ийн Магистр, докторын сургалтын журам”, БСШУ-ны сайдын 2014.09.12–ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралт,
- ХААИС-ийн захирлын 2015.06.26-ны өдрийн А/219 тушаалаар шинэчлэн батлуулсан протокол,
- 2021.03.18-ны өдрийн “Хүрээлэн буй орчин судлал” хөтөлбөрийн хорооны хурлаар батлуулсан протокол,
- 2021.04.01-ний Агроэкологийн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулсан протокол,

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн агуулгыг гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургуулиудын хөтөлбөртэй харьцуулсан.
- Нийт 29 магистр төгсгөснөөс 96% нь мэргэжлийн дагуу ажил эрхэлж байна.
- Мэргэжлийн суурь хичээлийг жилийн аль ч улиралд үзэх боломжтой.
- Нийт хичээлийн 25% нь лекц байдлаар, үлдсэн 75% нь оюутан бие даах байдлаар явагддаг.
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт хичээлийн 57.14%-ийг ургамлын нөөцийн чиглэлийн мэргэжлийн хичээл, 9.52%-ийг судалгааны арга зүйн хичээл, 33.33%-ийг ургамал судлалын салбар шинжлэх ухаануудын тухай мэдлэг олгох хичээлүүд эзэлж байна.
- Бусад тэнхимийн төгсөгчид болон үндсэн төгсөгчдийг эрэлтэд суурилсан 21 төрлийн сонгон судлах хичээлтэй.
- Гадаад болон дотоодын их сургуулиудаас шилжин ирж буй суралцагчдад 10-15 багц цагийг дүйцүүлэн тооцдог.

Анхаарах асуудал:

- Дотоодын их дээд сургуулиудын ижил агуулга бүхий хөтөлбөрүүдтэй харьцуулж, давуу талаа тодруулах, сул талаа сайжруулах.
- Бусад орнуудын их дээд сургуулиудын ижил төрлийн хөтөлбөртэй хичээл харьцуулалт хийсэн нь 3-10 хичээл л дүйж байна. Иймд бусад хичээлүүдийн судалгааг хийж, олон улсын жишигт хүргэх.
- Хөтөлбөрийн гуравдугаар зорилгод буй био-үйлдвэрлэлийн аргаар нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын нөөцийг нэмэгдүүлэх арга гэдгийг тодруулж, яг ямар аргаар, тухайлбал биотехнологийн, генетикийн аргаар гэх мэтээр тодруулах.

Зөвлөмж:

- “Ургамлын нөөц биоүйлдвэрлэл мэргэжлээр төгсөгч мэргэжлийн хувьд ургамлын мэргэжлийн өвөрмөц мэдлэгтэй инновацид суурилсан “судалгаа-үйдвэрлэл” хөгжүүлэх чадвартай” гэж заасан эрхэм зорилгынхоо хүрээнд цаашид инновацид суурилсан үйлдвэрлэл, био-үйлдвэрлэлийн талын хичээлүүд, сургалтаа ахиулах, төгсөгчдийн ажлыг энэ тал руу төвлөрүүлэхийг зөвлөж байна.

1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх

ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Ургамлын нөөц био-үйлдвэрлэл магистрын сургалтын хөтөлбөрийн 200 хуудас бүхий хэвлэмэл тайлан. Үүнд: 25 хичээлийн сургалтын төлөвлөгөө багтсан.
- 2021 онд тус хөтөлбөрөөр төгсөгчдөөс сургалтын хөтөлбөрийн талаар авсан сэтгэл ханамжийн судалгаа. Нийт 21 төгсөгч хамрагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийг доктор түүнээс дээш зэрэгтэй багш нар заадаг.
- Магистрын окуутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар онол дадлага хослуулан явуулдаг, ажил дээр зайлшгүй шаардлагатай мэдлэг олж авсан, ахисан түвшний мэдлэг олж авсан зэрэг эерэг хариултууд авсан нь сайшаалтай.

Анхаарах асуудал:

- Хичээл тус бүрийн агуулыг дахин сайтар нягталж, шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, орчин үеийн нэр томъёо, аргазүй, мэдлэг мэдээллээр шинэчилэх,
- Хичээлүүдэд ашиглагдаж буй ном сурах бичгийн жагсаалтыг шинэчилэх зайлшгүй шаардлагатай.
- Тухайн хичээлийн бие даалтаар зайлшгүй уншиж судлах ёстой олон улсын өгүүллийн нэрсийг тодорхой оруулж өгөх.

Зөвлөмж:

- Ургамлын ангилалзүйн хичээлд Flora of China, Flora of Sibira зэрэг олон улсын сайтуудыг ашиглах,
- Ургамлын ангилалзүйн нэршилд орчин үеийн ангилалзүйн системийг ашиглах,
- Ургамлын мониторинг хичээлд ашиглаж буй мониторингийн аргуудын нэр төрлийг олшруулж, тэдгээрийн давуу болон сул талыг тусгах,
- Сонгон судладаг 21 төрлийн хичээлд суралцагчдын сонголтонд суурилсан анализ хийж, мэргэшүүлэх хичээлийн нэр төрлийг өөрчлөх,
- Ашигт ургамлын нөөц хичээлийн конспектуудын ялгаа төдийлөн сайн харагдахгүй байна. Нөөцийн судалгааны арга нь овгуудын ялгаатай байдлаас илүү ургамлын амьдралын хэлбэрийн ялгаатай байдалд илүү илэрдэг. Энэ тал дээр анхаарна уу? Түүнчлэн нөөцийн судалгаа нь тархалтын судалгаатай нягт харилцан хамааралтай тул тархацын судалгааны аргазүйг тусгаж өгөх шаардлагатай.

1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- Мэрит төслийн хүрээнд Салхитын алт-мөнгөний ордын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулахад оролцсон.

- Ногоон экосистем ТББ-тай хамтран “Нийслэлийн нийтийн эзэмшлийн зүлэг талбайн мониторинг” нийслэлийн зүлэгжүүлэх зөвлөх ажилд багш, оюутнууд оролцсон. Тайлан. 2020. 13 хуудас.
- Оюу толгой ХК-тай хамтран “Говийн бүсэд ургамлын үржүүлгийн газар байгуулах” судалгааны ажил хийгдэж байна. Магистрант М.Буянжаргалын Агроэкологийн сургуулийн Экологийн тэнхимийн 2022.04.14-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн аргагүй, протокол,
- Дундговь аймагт хэрэгжүүлэх “Уур амьсгалд зохицсон ухаалаг мал аж ахуй судалгаа”-ны ажил,
- ХААИС-ын дэргэдэх “Гарааны ногоон дэлхийн чанар” ХХК, Сүхбаатар аймгийн ЗДТГ-тай байгуулсан “Аймгийн хэмжээний ургамлын зүйлийн бүрдлийн нарийвчилсан судалгааны ажлыг хийж, тархац, нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хамгаалах, зохистой ашиглах менежментийг нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний ажил -2021 он,
- ХААИС-ын дэргэдэх “Гарааны ногоон дэлхийн чанар” ХХК, “Туул голын сав газарт, Хан-Уул дүүргийн 12, 13-р хорооны нутаг дэвсгэрт уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажил - 2021 он,
- Орхон аймгийн ЗДТГ-тай байгуулсан “Орхон аймгийн эмийн ургамлын нөөцийг тогтоож, менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах” сэдэвт судалгааны ажил - 2020 он,
- Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан “Өмнөговь аймгийн бэлчээрийн төлөв байдал, ургамлан нөмрөгийн үнэлгээ” судалгааны ажил - 2022 он.
- FAO-ийн Integration of Climate Smart Approaches in Dundgovi aimag Livestock Sector Development plan, “Уур амьсгалд зохицсон Ухаалаг Мал Аж Ахуй” - 2021 он.
- Франц улсын хөрөнгө оруулалттай Field studies on the preservation of pasture resources in Bayankhongor aimag, The Pure Project Sarl. - 2021 он.
- Швейцарын хөгжлийн агентлаг, Ногоон алт төсөл “Монгол орны ойт хээрийн экосистем дэх голын эрэг татмын нөхөн сэргээлтийн туршилт, судалгаа” сэдэвт дэд төсөл -2020 он.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016 оноос хойш эмийн ашигт ургамлын нөөцийн судалгаа хийж эхэлсэн.
- Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн жишиг хөтөлбөр боловсруулах ажилд багш, магиструуд оролцсон.
- 2018 оноос хойш Олон улсын 2, дотоодын 14 төсөл хөтөлбөр, зөвлөх үйлчилгээний ажил хийсэн.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOFEL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилд 11 оюутан элссэн. Үүнээс 2020, 2021, 2022 онуудад 9 оюутан элссэн
- Элсэгчид сайт руу орж элсэх хүсэлтээ гаргадаг ба шаардагдах материал бүрдүүлсний дараа гадаад хэл, мэргэжлийн шалгалт өгдөг.
- Шалгалтанд авбал зохих онооны 60-аас доошгүй оноо авсан оюутан ONEMIS цахим системд нэвтэрч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хийж баталгаажуулснаар сургалтанд хамрах эрх үүсдэг.
- Элсэлтийн зар, гарын авлага буюу хэвлэмэл материал
- Магистрантур, докторантурт суралцах сургалтын гэрээ. МДС-ийн захирал баталсан.
- Элсэлтийн тушаал жил бүрээр 2019.10.01-ны тушаал 1 оюутан, 2020.04.16 -ны тушаал 3 оюутан, 2021.10.01 тушаал 2 оюутан элсэн орсон.
- ХААИС-ийн захирлын 2022.07.05-ны өдрийн А/194 тоот тушаал “ХААИС-ийн сургалтын журмыг шинэчилэн батлах тухай”
- Магистрант докторантын гарын авлага. ХААИС, Магистр, докторын сургууль. Улаанбаатар. 2022 он.
- Сэдэв удирдагч баталсан тушаал. 2022.11.02. А/248.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бүх магистрын элсэлтийг Магистр докторын сургууль цахимаар зарладаг.
- Ганцаарчилсан төлөвлөгөө хийж батлуулдаг
- Мэргэжлийн суурь 10 багц хичээл судалсны дараа судалгааны арга зүйг тэнхимээр хэлэлцүүлдэг.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх тал дээр дорвитой ажиллах
- Ажил олгогч нартай хамтран ажиллах, мэргэжлийн сурталчилгаа хийх

Зөвлөмж:

- Судалгааны магистр (2022.07.22, А/194 тушаал), эсвэл шинжлэх ухааны магистр (2014.11.14, А/398) гэдгийг нэг томъёотой болгох

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн хуваарь улиралд 10-12 цагийн багц байхаар төлөвлөсөн
- Мэргэжлийн суурь хичээлийн хуваарийг МДС-ийн захирал батлан нэгдсэн журмаар, харин мэргэшүүлэх хичээлийн хуваарийг хөтөлбөрийн хорооны зохицуулагч тухайн магистрын ганцаарчилсан төлөвлөгөөг үндэслэн хийдэг.

- Суралцах хичээлийн хуваарийг хөтөлбөрийн ахлагч, ЭНБД хянаж МДС-ийн захиарл баталгаажуулдаг.
- Магистрант докторантын гарын авлага (ХААИС, Магистр докторын сургууль).
- Магистр тус бүр ганцаарчилсан төлөвлөгөөтэй. Үүнд: мэргэжлийн хичээл болон мэргэшүүлэх хичээл, судалгааны семинар, магистрын ажил гэсэн үндсэн 4 хэсгийг 1.5-2 жилд хуваан төлөвлөж, удирдагч багш, МДС-ийн захирал батлаж ЭНБД хянаж, гарын үсгээр баталгаажуулсан байна.
- Агроэкологийн сургуулийн магистрант, докторантын судалгааны семинар 2022.11.30-2022.12.01-ны өдрүүдэд болж, нийт 15 магистрант илтгэл хэлэлцүүлсэн байна.
- ХААИС-ын захирлын 2022.11.02-ны өдрийн А/248 тоот тушаалаар нийт 73 магистрантын судалгааны ажлын сэдэв, удирдагч, харъяалагдах тэнхимийг нэгдүгээр хавсралтаар баталжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан бүр сонгон судлах хичээл болон цагийн ачааллыг удирдагч багшийн хамт боловсруулж батлуулдаг.
- Мэргэжлийн суурь 10 багц цагийн 4 багц цаг нь судалгааны арга зүй, 4 багц цаг нь судалгааны ёс зүй, бүтээл бичих судалгааны чиглэлээр хичээл ордог байна.

Анхаарах асуудал:

- Багц цагийн задаргаанд бие даалтын цаг их байна.

Зөвлөмж:

- Хичээл тус бүрийн стандартад байгаа багц цагийн задаргааны бие даалтын цагийн ачааллыг зохицуулах

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн харилцааны чадварыг тодорхойлсон санал асуулгын дүн.
- Сургахуйн дэвшилтэт арга, шинэлэг технологи хэрэгжүүлдэг талаар суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа.
- Хөтөлбөрийн багц цаг, агуулгын хүрээнд хичээлийн стандартыг боловсруулж хөтөлбөрийн хороо, экологийн тэнхим, Агроэкологийн сургуулийн ЭЗ-өөр хэлэлцэн баталгаажуулдаг
- Хичээлийн стандарт хөтөлбөр
- Магистрын гарын авлагаар шаардлагатай мэдээллээр хангадаг.
- Цахим орчинд Classroom платформ ашигладаг.
- Цахим хичээлд өгсөн үнэлгээний тайлан. 2020-2021 оны хичээлийн жил.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар багшлахуйн уламжлалт болон олон улсын аргуудыг эзэмшсэн шаардлага хангасан.
- Магистрантын судлаачийн болон мэргэжлийн ёс зүйн арга эзэмшүүлэх багц хичээл орохоос гадна сонгон суралцах боломжийг олгосон.
- Төсөлд суурилсан, орчинд суурилсан, асуудалд суурилсан арга зүйг ашигладаг

Зөвлөмж:

- Магистрант оюутанд оюуны өмч, патентийн талаар семинар зохион байгуулах

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр элсэн орж эхний улиралдаа суурь судалгааны арга зүйн 10 багц цагийн сургалтанд хамрагддаг. Ингэснээр судалгааны чиглэл, сэдвээ тодорхойлж чаддаг.
- Хөтөлбөрийн багш нарын судалгааны чиглэл нь тухайн хөтөлбөртэй холбоотой нарийсаж мэргэшсэн.
- Магистрант нь судалгааны ажлын сэдэв, арга зүйг экологийн тэнхимийн хурлаар хэлэлцэж батлуулдаг.
- ХААИС-ийн сургалтын журам
- ХААИС-ийн магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журам, 2021.09.12.
- Судалгааны арга зүйгээ батлуулсан. 2020-2022 онд нийт 8 оюутан.
- Удирдагч багш нарын 13 төсөлд магистрантууд хамрагддаг. 2018-2022 онуудад
- 2020-2022 онд шилдэг магистрантуудын судалгааны ажил. Өргөмжлөл 2011.11.17 магистрант С.Хишигжаргал, 2020.12.24 АЭС-ийн шилдэг илтгэл магистрант Г.Нандинцэцэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдэд зориулсан судалгааны чиглэлээс 10 гаруй нь дээрх хөтөлбөрийн судалгааны сэдэв байна.
- Удирдагч багш нарын хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөрт оролцдог.
- Судалгааны ажил шалгаруулдаг журамтай, судалгааны ажлыг дэмждэг тогтолцоотой.
- Хээрийн судалгаа, туршилтын талбайн судалгаа болон төсөлд магистр оюутны оролцоо сайн

Зөвлөмж:

- Туршилт судалгаа, лабораторийн цагийг нэмэгдүүлэх

2.5 Бүтээлч ажил

Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

- Магистрант оюутны судалгааны семинар зохион байгуулах Агроэкологийн сургуулийн захирлын тушаал 2020.04.27 А/31, 2021.03.25 А/25, 2022.11.01 А/169.
- Судалгааны семинарын хөтөлбөр, урилга.
- ISBN-тэй 5-6 эрдэм шинжилгээни сэтгүүлүүд. Тухайлбал: “Байгалийн шинжлэл” ХААИС-БУС, Journal of Agricultural science” болон Агроэкологи сэтгүүл, ХАА-н шинжлэх ухааны сэтгүүлд тайлант хугацаанд 11 өгүүлэл хэвлүүлсэн
- Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн материалууд.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төсөл, судалгаанд удирдагч багшийн хамт оролцох боломж өндөр.
- Оюутнууд төсөлд оролцсоноор судалгааны ажлын дата, материал цуглуулах боломж их
- Судлаач оюутны тэтгэлэг грант олгох журамтай.

Зөвлөмж:

- Магистр оюутны төсөл судалгаанд оролцсон бүтээлүүдийг үнэлэх тогтолцоотой болох

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн оюутны мэдлэг дүгнэх журмыг баримтлан стандарт (A,B,C,D,F) ба стандарт бус (CR, NC, E, W,R) үнэлгээтэй.
- Багшийн үнэлгээ 70%, улирлын шалгалтын үнэлгээ 30%
- Тайлант хугацааны магистрантын үнэлгээний голч 3.6-3.7 (магистрант Э.Баянзул, Г.Нандинцэцэг)
- БШУС-ийн 2021.10.06-ны А348 тушаал.
- ХААИС-ийн 2017.08.31 ны А187 тушаал ахисан түвшинд суралцагчдыг үнэлэх үнэлгээний журам.
- ХААИС-ийн сургалтын журам. (2022.07.05). 6.7 заалт магистр, докторын сургалтын үнэлгээ.
- Магистрын сургалтын хөтөлбөр баримт бичигт байгаа суралцахуйн үнэлгээг хичээл бүрээр гаргасан хичээлийн стандартууд.
- Магистрантын ур чадварын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гаргасан.
- 2016 оны opemis программын оюутны өөрийн үнэлгээ.
- Багшийн журнал.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үнэлгээний системд мэдлэг, хандлага, ур чадварын аргыг ашиглаж байгаа нь оюутны мэдлэг чадвар хандлагыг цогцоор нь үнэлэх боломж олгосон.
- магистрантыг үнэлэхдээ рубрикийн аргаас гадна хээрийн хэмжилтийн судалгаа, харьцуулалт хийх, тайлан бичих аргуудыг өргөн хэрэглэдэг байна.
- Магистрантын ур чадварыг хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр үнэлдэг нь тэдний голч үнэлгээг дээшлүүлэх боломж олгодог

Зөвлөмж:

- Шалгалт болон сорилын үнэлгээг ихэнхдээ тестээр авдаг, үүнийг үнэлгээний шинэлэг арга зүйг ашиглан явуулах

3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн магистр, докторын сургалтын журамд (2022.07.05) хичээл дүйцүүлэлт шилжилт хөдөлгөөний тухай бүлэг багтсан 4.3.5.2.
- Англи хэлний дүйцүүлэлтийн тогтолцоотой
- Хичээл дүйцүүлэх өргөдлийн маягттай
- ХААИС, Магистр, докторын сургууль. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах бага хурал. УБ. 2020. Илтгэлийн хураангуй. 63 хуудас.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Холбогдох журмын дагуу өөр хөтөлбөр болон гадуур суралцагчийн багц цаг болон үнэлгээний дүйцүүлэлтийг хийдэг.

Анхаарах асуудал:

- Тайлант хугацаанд дүйцүүлэх ажил явагдаагүй.

Зөвлөмж:

- Оюутан солилцооны хөтөлбөртэй болох (гадаад, дотоодын).

3.3 Магистрантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Ажлын бус цагаар суралцахуйн орчин бүрдүүлдэг. Ялангуяа лабораторийн үйл ажиллагаа нээлттэй байдаг
- Төгсөгчдийн санал асуулгаар хичээлийн бус цагаар зөвлөгч багш байдаг, сургалтын алба, хөтөлбөрийн хороо, удирдагч багш бүрэн мэдээллээр хангаж ажилладаг эсэх асуутанд 100% сайн, маш сайн гэж үнэлжээ.
- Санал асуулгад оролцсон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа (нийт 20 төгсөгч)
- Магистрантын ганцаарчилсан төлөвлөгөөг гаргахад удирдагч багш чиглүүлж өгдөг, ганцаарчилсан төлөвлөгөө.
- Магистрын гарын авлага шинэчлэгдэн гардаг.
- Зочин профессоруудыг урьж сургалтаас гадуур судалгааны семинар зохион байгуулдаг . Тайлант хугацаанд 9 удаагийн семинарын сэдэв

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил эрхэлдэг магистрант оюутнуудад ажлын бус цагаар суралцар орчин бүрдүүлсэн
- Удирдагч багшаа сонгох, хээрийн судалгаа хийх, илтгэл, семинар, хэлэлцүүлэг хийх зэрэг холбоотой бүхий л ажилд хөтөлбөрийн хороо, алба, тэнхимүүд зөвлөх үйлчилгээ сайн үзүүлдэг

Зөвлөмж:

- Төгссөн магистр оюутанд мэргэшүүлэх сургалт, семинар зохион байгуулах

3.4 Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Илрэл нотолгоо:

- Төслийн санхүүжилтээр багш нарт ажилласан өдрийн урамшуулал, магистрант оюутнуудад хээрийн судалгааны томилолт санхүүжилтийн эх үүсвэр болдог.
- 2021 онд Б.Бүрэнжаргал, П.Ариунсүрэн багш нар 300,000 ба 3545000 төгрөгийн санхүүжилттэй төсөл
- БОАЖЯ, ХХААХҮЯ, БСШУЯ, Солёын яамны захиалгат судалгааны төслүүд санхүүжилтийн эх үүсвэр болдог.
- ХААИС-ийн захирлын 2016.03.23-ны өдрийн А/45 тоот тушаалын хавсралт. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам. Магистрантын шилдэг илтгэлд 1000000 төгрөгийн тэтгэлэг олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш судлаачийн төслийн санхүүжилт магистрант оюутны судалгааны зарим санхүүжилт болдог.

Анхаарах асуудал:

- Төсөл, судалгааны санхүүжилтээс ургамлын нөөц, био-үйлдвэрлэл хөтөлбөрт орж ирэх хувь хэмжээ тодорхой бус.

3.5 Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ын захирлын 2016.03.23-ны өдрийн А/45 тоот тушаалын 1 дүгээр хавсралт. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам /Багшийн гарын авлага. 2017. 186-189х/. Магистрын шилдэг илтгэлд 1 сая төгрөгийн тэтгэлэг олгоно гэжээ.
- ХААИС-ийн захирлын 2016 оны А/45 тоот тушаалд ХАА салбарын залуу судлаачдад инновацийн грант олгох журам,
- ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам, 2022.07.05 А/194 тушаалын 4.2.2.7 заалт. Элсэлт авсанаас хойш 2007-2019 онд нийт 14 оюутан авсан. Тайлант хугацаанд 2 оюутан авсан.
- Тайлант хугацаанд удирдагч багшийн судалгааны 5 ажилд нийтдээ 5 оюутан оролцож судалгааны санхүүжилтийн эх үүсвэрийг олж чадсан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Судалгааны ажлыг дэмжин ажилладаг.
- 3.2 голчтой төгссөн бакалавр оюутан элссэн тохиолдолд магистрын төлбөрөөс 15% хөнгөлдөг.
- Удирдагч багшийн судалгааны төсөлд оюутнууд маш идэвхтэй оролцож, чадавхиждаг

Зөвлөмж:

- Ижил төстэй үйл ажиллагаа их дээд сургуулиудын эрдэм шинжилгээний ажилд оюутнуудыг татан оруулах

3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- Дундговь аймагт хэрэгжүүлэх “Уур амьсгалд зохицсон ухаалаг мал аж ахуй судалгаа”-ны төлийн бүрэлдэхүүн, зардлыг баталсан ХААИС-ийн захирлын 2021.06.14-ны өдрийн А/71 тоот тушаал.
- ХААИС-ын дэргэдэх “Гарааны ногоон дэлхийн чанар” ХХК, Сүхбаатар аймгийн ЗДТГ-тай байгуулсан “Аймгийн хэмжээний ургамлын зүйлийн бүрдлийн нарийвчилсан судалгааны ажлыг хийж, тархац, нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хамгаалах, зохистой ашиглах менежментийг нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний ажлын багийн бүрэлдэхүүнийг баталсан ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн захирлын 2021.08.30-ны өдрийн А/91 тоот тушаал,
- ХААИС-ын дэргэдэх “Гарааны ногоон дэлхийн чанар” ХХК, “Туул голын сав газарт, Хан-Уул дүүргийн 12, 13-р хорооны нутаг дэвсгэрт уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын багийн бүрэлдэхүүнийг баталсан ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн захирлын 2021.09.22-ны өдрийн А/103 тоот тушаал,
- Орхон аймгийн ЗДТГ-тай байгуулсан “Орхон аймгийн эмийн ругамлын нөөцийг тогтоож, менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах” сэдэвт судалгааны ажлын багийн бүрэлдэхүүнийг баталсан ХААИС-ийн захирлын 2020.05.22-ны өдрийн А/57 тоот тушаал.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар гадаад дотоодын төсөл, хөтөлбөрт магистр оюутнуудыг татан оруулдаг. Энэ нь оюутанд судалгааны материал, үр дүн цуглуулахад ач холбогдолтой. Мөн судалгааны санхүүжилтийн эх үүсвэр болдог.

Зөвлөмж:

- Гадаадтай хамтын ажиллагааны судалгааны төслүүдийг дэмжин ажиллах

3.7 Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрийн дипломын ажил
- Тайлант хугацаанд нийт 5 магистр төгссөн (2018 -1, 2020-1, 2021-1, 2022 -2 оюутан)
- Хөтөлбөрөөр суралцагч нь 33 багц цагийг судлан үнэлгээ авч, дүнг баталгаажуулснаар хөтөлбөрийн хороо, тэнхимийн саналыг үндэслэн МДС-ийн захирлын тушаалаар батлагдсан комисс нэгдсэн шалгалт авдаг.
- Магистрын төгсөлтийн ажлыг экологийн тэнхимийн хурлаар баталгаажуулдаг. Дараа нь хамгаалуулах зөвлөлийн нээлттэй хурлаар хэлэлцдэг. Зөвлөлийн шийдвэрийг нууц санал хураалтын дүнг үндэслэн гаргадаг.
- Зөвлөлийн 75%-иас доошгүй эерэг санал авсан тохиолдолд хамгаалсанд тооцдог.
- Саналын хуудас нь шаардлага хангасан, хангаагүй хувилбартай
- БСШУС-ын 2007 оны 187 тоот тушаал батлагдсан магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм.
- ХААИС-ийн сургалтын журам. 2022.07.05. 10.2.6 заалт.
- “Төгсөлтийн ажил бичих оюутны нэрс, сэдэв, удирдагч батлах тухай” ХААИС-ын Агроэкологийн сургуулийн захирлын 2021.05.12-ны өдрийн А/34 тоот тушаал.
- Магистрийн зэрэг хамгаалах зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэй 2022.04.28 ны А/106 тоот тушаал.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын эрдэм шинжилгээний ажлын сэдэв, удирдагчийн нэр ХААИС-ийн захирлаар баталгаажсан
- Экологийн тэнхимийн хурлаар дэмжигдсэн арга зүйн дагуу төгсөлтийн ажил бичигддэг
- Магистрын зэрэг хамгаалах журам, зөвлөлийн дүрэм сургуулийн веб сайтад тавигдаж түгээгддэг

Анхаарах асуудал:

- Магистрын бүтээлд ишлэл авсан бүтээлүүдийг сүүлийн үеийн ашигласан материалаар баяжуулах.

Зөвлөмж:

- Магистрын судалгааны сэдвийн саналыг ажил олгогчдоос авах.

3.8 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын диплом олгох журам.
- Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм. БСШУ-ны сайдын 2007 оны 187 тоот
- ХААИС-ийн сургалтын журам 2022.07.05. 10.5 заалт: Төгсөлтийн баримт бичиг.
- Магистрийн диплом авахад шаардлагатай баримт бичгийн 18 төрлийн жагсаалт буюу горилогчийн магистрын ажил тараасан жагсаалт, магистрын ажил, CD, хураангуй хүлээн авсан номын сангийн баримт, хамгаалалтын тов, хамгаалуулах зөвлөлийн гишүүдийн шүүмж, эрдэмтээс ирүүлсэн санал, эрдмийн зөвлөлийн ирц, хамгаалуулах зөвлөлийн хурлын дэг, хурлын протокол, тооллогын комисс томилох тогтоол, санал хураалтын тооллогын тогтоол, санал хураасан хуудас гэх мэт

- Магистрантын ХАА-н ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, CD

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн баримт бичиг авахад өөрөө бүрдүүлэх материал их, хүндрэлтэй.

Зөвлөмж:

- Магистрын дипломын бүтээл болон өгүүлэлд бүтээлийн хуулбарлалт (Plagiarism) шалгах тогтолцоо нэвтрүүлэх.
- Төгсөгчдийн холбоо байгуулж эргэх холбоотой ажиллах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

4.1 Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн сонгон шалгаруулалт, багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах ХААИС-ийн захирлын 2017.04.20-ны өдрийн А/86 тоот тушаал,
- ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам,
- Багшлах бүрэлдэхүүнийг ХААИС-ийн Захирлын 2014.11.14-ний өдрийн А/398 тоот тушаал “ХААИС-ын магистр, докторын сургалтын журам”
- Тус хөтөлбөрт нийт 2021-2022 оны байдлаар 19 багш байгаагаас 11 багш нь Экологийн тэнхимийн үндсэн багш нар, 7 багш ХААИС-ийн бусад бүрэлдэхүүн сургууль, нэгжийн багш, 1 багш эрдэм шинжилгээний хүрээлэнгийн харъяалалтай байна.
- Нөөцийн судалгаагаар тус хөтөлбөрт 1 багш 1-4 хичээл заах боломжтой бөгөөд тухайн жилийн хичээл сонголтоос хамааран 1-2 хичээл зааж байгаа нь багшийн хүрэлцээ хангалттай байгааг харуулж байна.
- Тус хөтөлбөрт хичээл заах боломжтой нийт 28 багш нөөцөнд байна.
- Ургамлын нөөц био-үйлдвэрлэлийн магистрын хөтөлбөрт нийт 28 багш, 10 магистрантад хичээл зааж байгаа нь 1 багшид 2.8 магистрант ноогдож байна. Энэ нь сургуулийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад багшийн хангамж сайн байгааг илтгэж байна.
- Багшийн вэб
- Багшийн гарын авлага
- Багш нарын танилцуулга, бүтээлийн жагсаалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “ХААИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ХААИС-ийн дүрэмд нийцүүлэн багшийн сонгон шалгаруулалт явагддаг.
- Шинжлэх ухаан, үйлдвэрлэл практикийн болон ахисан түвшний сургалт, судалгааны ажлын туршлагатай, мэргэшсэн багш нар ажилладаг. 2022 оны байдлаар доктор 19, дэд профессор 7.

- Нийт хичээл ордог багш нар 100% доктор зэрэгтэй, 40% нь дэд профессорын зэрэглэлтэй, ургамлын ангилалзүйч, бэлчээр судлаач, хөрс судлаач, молекул биологи, микробиологи, зайнаас тандангийн чиглэлээр мэргэшсэн багш нар хичээл зааж байна.
- Судалгааны ажлын удирдагч нь докторын зэрэгтэй байна.
- Тухайн хөтөлбөрийн магистрын хөтөлбөрт хичээл заадаг багш нар нь 10, түүнээс дээш жилийн хугацаанд тухайн салбартаа ажилласан, гадаад, дотоодын төслүүдийг удирдахын зэрэгцээ, төсөлд оролцдог, судалгаа шинжилгээний ажил хийж, зөвлөгөө өгдөг.
- Сүүлийн 5 жилд 12 ном, 15 гарын авлага хэвлүүлжээ.

4.2 Багшлахуйн үнэлгээ

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын хэмжээнд 2019.01.01-ээс мөрдсөн “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль,
- ХААИС-ийн ректорын 2002.11.20-ны өдрийн 156 тоот тушаалаар баталсан “Багшийн хөгжил” хөтөлбөр,
- ХААИС-ийн захирлын 2021.09.22-ны өдрийн А/143 тоот “Журам батлах тухай” тушаал. Уг тушаалд тус сургуулийн эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийн зохиогч, Магистрант, докторант оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийг сонгон шалгаруулах журмыг нэг болон хоёрдугаар хавсралтаар баталжээ.
- Магистрт докторын сургуулийн “Цахим хичээлд хөндлөнгийн үнэлгээ хийсэн ажлын хэсгийн тайлан (2020-2021 оны хичээлийн жилийн II-р улирал). Нийт 66 багшийг үнэлж, дунджаар 69.9 оноо авсан байна.
- “Багшийн гарын авлага-2017”-ын Хавсралт 3. Профессор багшийн эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйлчилгээ буюу “Б” цагт баримтлах чанарын түвшин, харгалзах цаг /59-62 хууд/.
- Багшийн их сургуульд оруулсан хувь нэмрийг жил бүр үнэлсэн нотолгоонууд.
- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээнүүд,
- ХААИС-ийн багш нарыг 3 жил тутам аттестачилалд хамруулан хөндлөнгийн үнэлгээ,
- Жил бүр бүрэлдэхүүн сургуулийн шилдэг сурган хүмүүжүүлэгч, шилдэг судлаач багш, шилдэг залуу багш гэсэн номинацаар багш болон тэнхимийг шалгаруулдаг.
- Аэроэкологийн сургуулийн Шилдэг тэнхим - 2019, 2020 онд.
- ХААИС-ийн профессор багш ажиллуулах журмын дагуу (ХААИС-ийн ректорын 2016 оны А/87 тоот журам) илүү цагийн урамшуулал олгох систем - Бүх багш нар.
- ХААИС-ийн Шилдэг сурган хүмүүжүүлэгч багш. 2018, 2021 онд П.Ариунсүрэн, 2019 онд Т.Баягал-Амар, 2022 онд О.Бүрэнжаргал.
- Аэроэкологийн сургуулийн Шилдэг судлаач багш - 2019 онд О.Бүрэнжаргал, 2021 онд Ш.Оюунтуяа.
- Тус хөтөлбөрийн 21 багш салбарын тэргүүн, 5 багш Алтан гадас одонгоор, 2 багш Хөдөлмөрийн гавъяаны одонгоор тус тус шагнагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 9 багш шилдэг сурган хүмүүжүүлэгч, шилдэг судлаач болсон.
- 2016, 2019, 2020 онд Агроэкологийн сургуулийн шилдэг тэнхим болсон.
- Багшийн хэрэгжүүлж буй төслөөс их сургуульд оруулсан хувь нэмрийг (мөнгөн дүнг) жил бүр үнэлж, батламж олгодог.

- Дадлагажигч багш 2 жил, багш, ахлах багш, дэд профессор 3 жил, профессор 5 жил тутамд багшийн хөгжил, чадамжийн түвшингээ үнэлүүлдэг.
- Магистрын шатны суралцагсдаас багшийн сургалтын ур чадвар, заах арга, ес зүйн талаарх сэтгэл ханамжийн судалгааг 2020 оноос авч эхэлсэн

Анхаарах асуудал:

- Доктор, магистрын хөтөлбөрт зааж байгаа хичээлийн үнэлгээний тогтолцоо нь багшийн хөгжлийг дэмжихгүй, бодитой үнэлэгдэхгүй байна.
- Багшийн цагийн ачаалал их байна.
- Магистрт зааж байгаа хичээлийг багшийн жилийн хичээл заах ноогдолд оруулах

4.3 Багшийн хөгжил

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн ректорын 2002.11.20-ны өдрийн 156 тоот тушаалаар баталсан “Багшийн хөгжил” хөтөлбөр,
- “Багшийн хөгжил” хөтөлбөрийн дагуу LCE програм,
- Багш, судлаачдыг бэлтгэх, чадавхыг нь бэхжүүлэх талаар ХААИС-ийн 2019-2028 оны стратеги төлөвлөгөө,
- “Багшийн програм” (<http://teacher.muls.edu.mn>)
- ХААИС-ийн захирлын “Цахим хичээлд хөндлөнгийн үнэлгээ хийх” тухай 2021.03.17-ны өдрийн А/37 тоот тушаал.
- ХААИС, Сургалтын бодлого зохицуулалтын алба, Магистр докторын сургууль. Цахим хичээлд хөндлөнгийн үнэлгээ хийсэн ажлын хэсгийн тайлан (2020-2021 оны хичээлийн жилийн II-р улирал). Улаанбаатар. 2021 он.
- ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн захирлын 2019.04.01-ний өдрийн А/37 тоот тушаалаар “Экологийн VIII олимпиад зохион байгуулах”-ад оролцсон.
- Тус хөтөлбөрийн багш давхардсан тоогоор мэргэжлийн чиглэлээр 18, заах аргын чиглэлээр 7, мэдээллийн технологийн чиглэлээр 8, англи хэлний чиглэлээр 2, нийт 37 багш сургалтанд хамрагдсан.
- Доктор О.Бүрэнжаргал Австри улсын ВОКУ их сургуулийн “Natural resource and life science” сургуулийн Ойн тэнхимд, доктор М.Хишигжаргал Герман улсын Геотенгений их сургууль, Фрайбургийн их сургуульд, доктор Т.Байгал-Амар Испани улсын Гироний их сургуульд, доктор Ш.Оюунтуяа Австрийн Зальцбургийн их сургууль, Нидерландийн Вагениний их сургууль, Н.Цэгмид ОХУ-ын Тимерязевийн ХАА-н академид тус тус суралцаж мэргэжил дээшлүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Багшийн хөгжил” хөтөлбөрийн дагуу LCE програм нэвтрүүлсэн.
- Сурган заах арга зүй, судалгааны чадавхи дээшлүүлэх, мэдээлэл технологийн чиглэлээр багш нарыг мэргэжил дээшлүүлсэн.
- Ахисан түвшний оюутнуудад хичээл заадаг багш нарын сэтгэл ханамж, суралцагсдад ээлтэй орчин бүрдүүлэх, сургахуйн чадамжийг сайжруулах, үнэлгээ, хөтөлбөрийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох зорилгоор тогтмол судалгаа авч судалгааны үр дүнд анализ хийж ажиллах төлөвлөгөөтэй.

Анхаарах асуудал:

- Сургуулийн төсвөөс хэдэн хувийг сүүлийн жилүүдэд багшийн хөгжилд төсөвлөн, зарцуулсан талаар анализ хийхэд санхүүгийн жилийн тайлан жилээр гарах

учраас онцлон төсвийн хэдэн хувь нь эрдэм шинжилгээнд зарцуулсныг харуулсан тодорхой мэдээлэл байхгүй байна.

4.4 Судалгаа ба хөгжил

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Исланд улсын “Нэгдсэн үндэсний их сургууль”-ийн дэргэдэх “Газрын доройтлыг бууруулах хөтөлбөр”-өөс санаачилан, ХААИС-ийн Агроэкологийн сургууль, Монголын бэлчээр ашиглагчдын холбоо, УЦУОШГ хамтран “Байгалийн нөөцийн менежмент: Мэдээлэл боловсруулалт, үр дүнг ашиглан ур чадварыг хөгжүүлэх нь” сэдэвт олон улсын сургалтыг 2019.05.18-26-ны өдрүүдэд зохион байгуулсан.
- Сүүлийн 5 жилд төсөл 29, гэрээт болон захиалгат ажил 34, ном сурах бичиг 35, нэг сэдэвт монограф 7, гарын авлага 34, IF-тай сэтгүүлд 16, олон улсын сэтгүүлд 21, дотоодын сэтгүүлд 56 өгүүлэл хэвлүүлсэн.
- Хөтөлбөрийн багш нараас ХАА-н шинжлэх ухааны мэргэжлийн сэтгүүлийн редакцийн зөвлөлд М.Хишигжаргал, Ш.Оюунтуяа, ШУА-ын сэтгүүлийн редакцийн зөвлөлд Ш.Оюунтуяа, олон улсын “Forests” http://www.mdpi.com/journal/forests/special_issues/mycorrhizal_fungi мэргэжлийн сэтгүүлд О.Бүрэнжаргал нар ажиллаж мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 5 жилд олон улсын имфакт фактор бүхий сэтгүүлд 16 өгүүлэл хэвлүүлсэн ололттой байна.
- Ургамлын нөөц, био-үйлдвэрлэл мэргэжлийн магистрын хөтөлбөрийн сургалт нь дадлагад илүү суурилсан байдаг учраас магистрант оюутан бүр судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж, түүнийг үйлдвэрлэлд хэрэгжүүлэхэд багш нар хамтран ажилладаг.
- Сүүлийн жилүүдэд гарсан биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, Генетикийн нөөцийн тухай хууль зэрэг олон улсын болон дотоодын хууль тогтноомж, зорилт, алсын хараа хөтөлбөрийн хүрээнд ашигт, нэн ховор, ховор ургамлын тархацнц нөөцийг тогтоох, үйлдвэрлэлийн нөөц тогтоо, тарималжуулах зэрэг үйл ажиллагааны чиглэлээр Япон улсын ЖАЙКА ОУБ, дотоодын БСШУЯамны ШУТсан, ХХААЯам болон бусад уул уурхай, үйлдвэр зэрэг олон байгууллагуудтай хамтран олон улсын болон дотоодын захиалгат болон гэрээт төслийг хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Импакт фактор бүхий сэтгүүлүүдэд хэвлүүлсэн өгүүлүүдийг чанараар (Q1-4) эрэмбэлэх, шагнал урамшуулал олгох

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

5.1 Сургалт, судалгааны орчин

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш, суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо: Нийт 17 лаборатори, танхим, номын сангийн 6 өрөөтэй танилцав.

- Ургамлын үрийн экологийн лаборатори
- Шавж судлалын лаборатори
- Ургамлын үржүүлгийн лаборатори
- Хөрсний лаборатори
- Ургамлын стресс, физиологийн лаборатори
- Дендрозкологийн лаборатори
- Микробиологийн лаборатори
- Газрын кадастрын лаборатори
- Геоэкологийн лаборатори
- Лекцийн өрөө -2 өрөө
- Бэлчээрийн газрын судалгааны лаборатори - Фотомониторинг хийдэг
- ТХГН-ийн экосистемийн үйлчилгээний менежментийн төв
- Аялал жуулчлалын системийн шинжилгээний лаборатори
- Байгаль орчны шинжилгээний лаборатори - Төв, Батсүмбэрийн Үдлэгт 2 га талбайд ургамлын судалгааны талбайтай (Төрийн байгууллагын газар эзэмших гэрчилгээгээр баталгаажсан. Дугаар 000001060. 2019.03.12.)
- Ургамлын гербарийн сан
- Шинэ номын сан
- ХААИС. Магистр докторын сургууль. Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны ажлын тайлан (2016-2019 оны хичээлийн жилийн судалгааны ажлын харьцуулалт). Улаанбаатар. 2021 он.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийт 41 өрөө тасалгаатай. Сургалт судалгаа хийдэг 8 лабораторитай.
- Лабораториуд орчин үеийн техник, технологиор хангагдсан.
- Лекцийн танхимууд ухаалаг дэлгэцтэй.
- Зайнаас тандан болон статистикийн хичээл ордог өрөөнүүд орчин үеийн компьютерээр хангагдсан.
- Сургалтын орчинг сайжруулах талаарх саналд 21 магистр оролцсоноос 99% нь сайн, маш сайн гэсэн үнэлгээ өгсөн.
- Шинэ номын сан нь нийт 4 танхим, нэг удаадаа 150 оюутан хүлээн авах чадалтай. Сургалт эрдэм шинжилгээ болон сургалтын гэсэн 2 фондтой. Магистр докторын бие даах өрөөтэй.
- Тус хөтөлбөрийн гербарийн санд 69 овгийн 265 төрөлд хамаарах 518 зүйл ургамлын 1500 хуудас байгалийн ургамлын цуглуулга хадгалагдаж байна.

Анхаарах асуудал:

- Лабораториудад буй багаж төхөөрөмж, техник технологиудыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах,
- Оюутанд оногдох хичээлийн танхим, тасалгааны талбайн хэмжээг жил бүр харьцуулж гаргасан. Энэ нь тухайн жилийн оюутнуудын элсэлтийн тооноос хамаарах тул оновчтой баримт биш юм. Иймд нийт анги, танхим, өрөө тасалгаануудын талбайг нэг оюутанд оногдох ёстой талбайн стандарттай харьцуулж тооцох нь зүйтэй.

Зөвлөмж:

- Номын санчдын одоогийн тоо 11 байгаа нь стандартаас доогуур байна. Тус сургууль нь нийт 6 мянга орчим оюутантай тул оюутны тоонд харьцуулж, номын санчдын тоог нэмэгдүүлэх.

- Орчин үеийн, үнэтэй тоног төхөөрөмжөөр хангагдсан лабораториудад бусад их дээд сургууль, хүрээлэн, судлаачдын судалгаа шинжилгээг хийх, хамтран ажиллах боломжийг бүрдүүлж өгвөл сайн байна.

5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сан нийт 60000 орчим номтойгоос тус хөтөлбөрт хамаарах 37 нэр төрлийн 576 ширхэг ном, сурах бичиг байна.
- Оюутнуудын өөрөө өөртөө үйлчлэх хэвлэх машинтай.
- Оюутнуудыг J Stor, BioOne, OECD iLibrary, Oxford Meicine online, ARDI Research for Innovation, OARE Research in the Environment, Hinari Research for Health, GORA Research in Agriculture гэсэн 8 олон улсын сэтгүүлийг онлайнаар үзэх боломжоор хангасан.
- ХААИС-ийн Мал аж ахуйн шинжлэл, Агроэкологи, Байгалийн шинжлэл, Journal of Agricultural Sciences зэрэг сэтгүүлүүдтэй.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын 8 сэтгүүлийг онлайнаар үзэх боломжоор хангасан.
- Номын сангийн номын хүрэлцээ хангалттай сайн. Сүүлийн 5 жилд 2000 гаруй ном сурах бичиг, 200 гаруй эрдмийн ажлуудыг 60 орчим сая төгрөгөөр худалдан авч, номын санг баяжуулсан.
- Магистр, докторын ажлуудыг цахимжуулсан.
- ХААИС-ийн Мал аж ахуйн шинжлэл, Агроэкологи, Байгалийн шинжлэл, Journal of Agricultural Sciences зэрэг сэтгүүлүүдийг жилд 1-2 удаа хэвлүүлж, өөрсдийн судалгаа шинжилгээний ажлуудын үр дүнг хэвлүүлдэг.
- Сургалтанд хэрэглэдэг гербарийн сантай.
- Сургалтанд SamplePoint, DIMA, ArcGIS програмуудыг ашигладаг.
- Хичээлийг цахим хэлбэрээр Google class room, Teams ашиглан явуулдаг.

Анхаарах асуудал:

- Орчин үеийн үеийн ном, сурах бичиг хангалтгүй.
- Ургамлын нөөц, био-үйлдвэрлэлийн чиглэлийн мэргэжлийн ном, сурах бичиг, сэтгүүлийн тоо хангалтгүй.

Шаардлага:

- Номын санг олон улсад ашиглагддаг орчин үеийн номоор баяжуулах шаардлагатай.
- Номын санг ургамлын нөөц, био-үйлдвэрлэлийн чиглэлийн мэргэжлийн ном, сурах бичиг, сэтгүүлээр баяжуулах шаардлагатай.

5.3 Төсөв, санхүүжилт

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-д нийт жилдээ 750,0 сая төгрөгийг магистрын болон докторын орлогоор бүрдүүлдэг. Нийт зардал нь 412,0 сая төгрөг байна.
- ХААИС-ын захирлын 2022.06.23-ны өдрийн А/179 тушаал. Хөтөлбөрийн магистрын төлбөр 1 кредит- 115000 ₮.
- Нэг суралцагчид ноогдох шууд зардал 89.4% шууд бус зардал 7.3% байдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 5 жилд ном сурах бичигт 59.8 сая, лаборатори тохижуулах, багаж тоног төхөөрөмж худалдан авахад гаднаас 351.6 сая төгрөгийн санхүүжилт хийжээ.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захиргааны зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

6.1 Засаглал ба удирдлага

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Удирдлагын мэдээллийн систем. Гарын авлага. Улаанбаатар. -50 хуудас
- Ургамлын нөөц биоүйлдвэрлэлийн магистрын хөтөлбөр нь “Хүрээлэн буй орчин судлал” магистр, докторын хөтөлбөрийн хороонд харъяалагддаг.
- Уг хөтөлбөрийн хороо нь Агроэкологийн сургуулийн захирлын 2019.03.26-ны өдрийн А/69 тоот тушаалаар батлагдсан,
- ХААИС. Агроэкологийн сургууль. Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа (2018-2020 оны хичээлийн жил). УБ. 2020.
- “Хүрээлэн буй орчин судлал” магистрын хөтөлбөрийн бүрэлдэхүүнийг 2019 болон 2022 онд $\frac{1}{3}$ хэмжээгээр сольсон. Үүнийг магистрын ажлууд доторх магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл гэсэн бүлгээр нотлов.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ургамлын нөөц биоүйлдвэрлэлийн магистрын хөтөлбөр нь “Хүрээлэн буй орчин судлал” магистр, докторын хөтөлбөрийн хороонд харъяалагддаг.
- Удирдлага мэдээллийн ONEMIS систем ашигладаг.
- Суралцагчдын дунд сэтгэл ханамж, сургалтын агуулга зэрэг шаардлагатай судалгаануудыг сүүлийн 2 жилд хийсэн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хороог 2 жил тутамд 1 удаад гишүүдийн $\frac{1}{3}$ -ийг солино гэж заасан боловч хорооны гишүүдийг сольсон талаар албан бичиг байхгүй байна. Бид зөвхөн магистрын ажил дээрх хорооны гишүүдийн нэрээр нотолсон тул үүнийг тодорхой болгох.
- Хөтөлбөрийн хороо нь хичээл тус бүрийн хөтөлбөрийн агуулгыг сайтар хянаж батлах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хорооны гишүүд, ялангуяа ахлагч, зохицуулагч, хяналтын гишүүдийг 2 жил тутамд солих нь монопол байдлаас сэргийлэх давуу талтай.

6.2 Ажилтнууд

Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих ур чадвар, туршлагатай байна. Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын хөтөлбөрийн нэгдсэн удирдлагын нэгж нь МДС байдаг.
- Магистр докторын сургууль нь захирал, хөтөлбөрийн эрхлэгч, 2 туслах ажилтантай.

- ХААИС-ийн нийтлэг үйлчилгээний албанд нийт 94 хүний бүрэлдэхүүнтэйгээр ХААИС-ийн сургалт явуулах таатай орчинг бүрэлдүүлэн ажиллаж байна.
- 2019-2022 оны хичээлийн жилд ХААИС-ийн хэмжээнд 22 номын санч ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийтлэг үйлчилгээний албанаас “Ажлын байран дахь хамтын ажиллагаа-ёс зүйн ухамсар” сургалтыг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Захиргааны туслах ажилтны тоог оюутнуудын тоотой харьцуулж, нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Захиргааны ажилтнуудын веб, программ, системтэй ажиллах чадварыг сайжруулж, оюутнуудад учирч буй чирэгдлийг багасгах
- Номын сангийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын MNS 5742:2019 стандартад нийцүүлэн, шаардлагатай зайлшгүй орон тоог нэмэгдүүлэх

6.3 Удирдлагын мэдээллийн систем

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн бүтэц зохион байгуулалтын систем
- OneMIS v2.0 удирдлагын мэдээллийн системийг ашигладаг. Энэ нь дараах системүүдээс бүрддэг ч зарим нь бүрэн ажиллаж эхлээгүй.
 - Сургалтын албаны программ
 - Хүний нөөцийн программ
 - Сургалтын төлбөр программ
 - Оюутны веб
 - Багшийн веб
 - Санхүүгийн программ
 - Системийн удирдагчийн програм
 - Мэдээллийн сангийн удирдлагын програм
 - Системийн хяналтын програм
 - Онлайн төстийн дэд систем
 - Номын сангийн програм
 - Эрдэм шинжилгээний систем
 - Тайлангийн нэгдсэн систем

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- OneMIS v2.0 удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлж байгаа.

Анхаарах асуудал:

- Сургалтын албаны программуудыг сайжруулах, ашиглахад илүү амар болгох тал дээр анхаарах

6.4 Мэдээллийн ил тод байдал

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал,

багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС–ийн МДС-аас гаргадаг шинэ элссэн магистрантуудад зориулсан гарын авлага нь 2008, 2009, 2011, 2012, 2014, 2022 онуудад сайжруулж шинэчлэгдсэн байдаг.
- <http://graduate.muls.edu.mn/>,
- <http://muls.edu.mn/>

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МДС-ийн вэб сайт, фэйсбүүк хуудасны өдөр тутмын үйл ажиллагаагаар сургуулийн удирдлага, сургалтын алба болон бусад газраас ирсэн мэдээллийг түгээдэг давуу талтай.

Анхаарах асуудал:

- Уг хөтөлбөр нь 20 гаруй жил элсэлт авч байгаа боловч нийтдээ 20 гаруй төгсөгчидтэй. Иймд цаашид элсэгчдийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах, сургалт мэдээллийн тогтолцоог сайжруулах

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

7.1 Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөгчдийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга, тогтмол давтамжтайгаар хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС, Сургалтын бодлого зохицуулалтын алба. Хөтөлбөрийн чанарын менежментийн гарын авлага. Улаанбаатар. 2020 он.
- Чанарын удирдлага зохицуулалтын албатай.
- ХААИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журам"-ын 2021 оноос хэрэгжиж байна.
- Хөтөлбөр харьяагдаж буй тэнхимийн зүгээс “Ургамлын нөөц биоүйлдвэрлэлийн хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө 2017-2027”-ийг боловсруулан ажиллаж, 64%-ийн биелэлттэй явж байна.
- Магистр, докторын хөтөлбөрөөр суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа. 2021 он.
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны тайлан. 2022 он.
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа. 2022 он.
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа. 2022 он.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Ургамлын нөөц биоүйлдвэрлэлийн хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө 2017-2027” төлөвлөгөөний гүйцэтгэл 64% байгаа нь сайшаалтай.

Анхаарах асуудал:

- 2008 оноос хойш нийт 29 магистрын ажил бичигдсэн боловч био-үйлдвэрлэлийн чиглэлийн ажил харьцангуй цөөн.
- Хөтөлбөрийн программыг Олон улсын сургуулиудын программуудтай харьцуулахаас гадна дотоодын их дээд сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулж, давуу талаа тодотгох.

Зөвлөмж:

- Ажил олгогчтой хийсэн ярилцлагаас оюутнуудын англи хэлний мэдлэг, статистик боловсруулалтын чадвар дээр анхаарч ажиллах. Мөн хувь хүн талаас нь хариуцлагатай, хүнлэг чанартай байх зэрэг хувь хүний төлөвшил тал дээр илүү сайн ажиллаж өгөхийг хүссэн.
- Төгсөгчидөөс суурь хичээлийн программ-д Англи хэл, Математик статистик, үрийн биологи, GIS-ыг NDVI зэрэг мэдээлэлтэй холбодог хичээлүүд орохыг санал болгосон.
- Монгол Улсын их сургуульд Биологийн нөөцийн хөтөлбөр байдаг бөгөөд уг хөтөлбөрийн хичээлийн программтай өөрсдийн сургалтын хөтөлбөрийн агуулга, программыг харьцуулахыг зөвлөж байна.

7.2 Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Магистр докторын сургуулийн захирал Б.Баттөрийн 2021.03.18-ны өдөр баталсан “Ургамлын нөөц биоүйлдвэрлэл магистрын хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө 2017-2027” байна. Уг төлөвлөгөө нь нийт 2 үндсэн, 6 дэд хэрэгжүүлэх стратегиас бүрдсэн.
- ХААИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журамд нийцүүлэн боловсруулж, Хүрээлэн буй орчин судлал хөтөлбөрийн хорооны 2021.03.18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Уг хөтөлбөр 2001 онд батлагдаж, 2004 оноос магистрын элсэлт авч, үйл ажиллагаа явуулсан.
- Анх удаа магадлан итгэмжлэлд орж байгаа хөтөлбөр

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог сайжруулах

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн Хангасан (2)	Хэсэгчлэн Хангасан (1)	Хангаагүй (0)	Дүгнэлт
1	Магистрын хөлбөрийн зорилго, агуулга	5x2			Бүрэн хангасан
2	Магистрын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	5x2			Бүрэн хангасан
3	Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	8x2			Бүрэн хангасан
4	Багшлах бүрэлдэхүүн	4x2			Бүрэн хангасан
5	Нөөц ба санхүүжилт	2x2	1x1		Бүрэн хангасан
6	Удирдлага ба мэдээллийн систем	4x2			Бүрэн хангасан
7	Чанарын баталгаажуулалт	2x2			Бүрэн хангасан
Дүгнэлт		ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийн “Ургамлын нөөц, биоүйлдвэрлэл” хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Б.Оюунцэцэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ж.Энхтуул/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../О.Мөнхзул/

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

ШАЛГУУР	ЗӨВЛӨМЖ
---------	---------

1. Магистрын хөлбөрийн зорилго, агуулга	- Хөтөлбөрийг орчин үетэй нийцүүлэн, ажил олгогчдын эрэлтэд тааруулан сайжруулах (ангилалзүйн нэршил, ангилалзүйн шинэ систем, англи хэл, статистик анализ, дээд математик, молекул биологи, үрийн биологи, селекц, гадаад хэл дээр өгүүлэл бичих аргазүй, GIS). - Ажил олгогч, төгсөгчид, оюутнуудтай ярилцах үед заавал үзэх мэргэжлийн хичээлд ургамлын ангилалзүй, статистик, англи хэлний хичээлүүдийг тусгаж өгөх санал гарсаныг харгалзан үзэх.
2. Магистрын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	- Магистрын хичээлийн стандартыг ахисан түвшинд боловсруулах нь зүйтэй.
3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	- Магистрын төгсөлтийн ажил болон магистрант оюутны төгсөх болзол хангасан эрдэм шинжилгээний өгүүлэлд бүтээлийн хуулбарлалт/plagiasm-ыг шалгах тогтолцоог хэрэгжүүлэх, - Төгсөгчидтэйгээ эргэх холбоотой ажиллаж, сүүлийн үеийн арга аргачлалаар мэргэшүүлэх сургалт, семинар тогтмол зохион байгуулах, хөтөлбөрийг сайжруулахад тэднийг татан оролцуулах.
4. Багшлах бүрэлдэхүүн	- Багшийн магистр, докторт хичээл заах цагийг багшийн ноогдол цагт оруулж өгөх,
7. Чанарын баталгаажуулалт	-Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа авсан боловч дүн шинжилгээ хийсэн байдал хангалтгүй байна. Иймээс анализ хийж хөтөлбөрийн сайжруулалтанд тусгах шаардлагатай.
ШААРДЛАГА	
5. Нөөц ба санхүүжилт	<ul style="list-style-type: none"> • Номын санг олон улсад ашиглагддаг орчин үеийн номоор баяжуулах шаардлагатай. • Номын санг ургамлын нөөц, био-үйлдвэрлэлийн чиглэлийн мэргэжлийн ном, сурах бичиг, сэтгүүлээр баяжуулах шаардлагатай.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Ажилл асан жил	Оролцсон эсэх	Эрдмийн зэрэг, цол
1	П.Ариунсүрэн	АЭС, Экологийн тэнхим	28	Оролцсон	Доктор (Ph.D), дэд профессор
2	Ш.Оюунтуяа	АЭС, Экологийн тэнхим	27	Оролцсон	Доктор (Ph.D), дэд профессор

3	Х.Баярмаа	АЭС, Экологийн тэнхим	29	Оролцсон	Доктор (Ph.D), дэд профессор
4	О.Бүрэнжаргал	АЭС, Экологийн тэнхим	20	Оролцсон	Доктор (Ph.D), дэд профессор
5	Т.Байгал-Амар	АЭС, Экологийн тэнхимийн эрхлэгч	26	Оролцсон	Доктор (Ph.D)
6	Д.Болормаа	МАНЭШ хүрээлэн	30		Доктор (Ph.D), дэд профессор
7	Д.Түмэнжаргал	Оюу толгой уурхайн нөхөн сэргээлтийн зөвлөх	36	Оролцсон	Доктор (Ph.D), дэд профессор
8	Д.Ундармаа	АЭС-Тарималжуулалт –ой-ландшафтын тэнхим	30		Доктор (Ph.D), дэд профессор
9	Д.Түвшинбаяр	ХААИС, ГМТэнхим	25		Доктор (Ph.D), дэд профессор
10	Т.Алтанзаяа	ХААИС, МААБС	26	Оролцсон	Доктор (Ph.D), дэд профессор
11	Г.Биндэръяа	ХААИС, МААБС	26	Оролцсон	Доктор (Ph.D)
12	Н.Мөнхзул	ХААИС, ЭЗБС	18		Доктор (Ph.D)
13	И.Баярбат	ХААИС, МААБС	18		Доктор (Ph.D)
14	Ц.Нямхүү,	ХААИС, МААБС	19		Доктор (Ph.D)
15	Т.Уламбаяр	ХААИС, МААБС	11		Доктор (Ph.D)
16	Н.Дамбадаржаа	Газар Тариалан тэнхим	11		Доктор (Ph.D)
17	Н.Цэгмид	АЭС, Экологийн тэнхим		Оролцсон	Доктор (Ph.D)

18	Б.Ариунжаргал	АЭС, Экологийн тэнхим		Оролцосн	Доктор (Ph.D)
19	Б.Лхамсүрэн	АЭС, Экологийн тэнхим		Оролцсон	Доктор (Ph.D)
20	М.Оргилболд	АЭС, Экологийн тэнхим			Доктор (Ph.D)

Нийт 11 багш танхимаар оролцов.

Шинжээчид, багш нарын хоорондох ярилцлага:

- Хичээлийн багц цаг яаж задардаг вэ? Нэг оюутан 5 хичээл үзсэн гэвэл бүх хичээлд 75% бие даалт хийсэн гэсэн үг. Энэ нь тухайн оюутанд хир ачаалалтай вэ? Үүнийг яаж зохицуулах вэ?
 - ◆ 3 багц цаг нь 144 цаг гэсэн үг. 75% нь бие даалт, 25% нь лекц байдаг. Энэ нь тухайн оюутан өөрөө сонгосон гэсэн үг. Ерөнхийдөө максимум нь 4 хичээл сонгохоор байдаг.
- Мэргэжлийн суурь хичээл хэзээ явагддаг вэ?
 - ◆ Тухайн оюутны хувьд эхний улирал гэсэн үг. Хавар болон намрын аль ч улиралд үзэх боломжтой. Өөрөөр хэлбэл нэг хичээлийн жилд 2 удаа сонгох боломжтой гэсэн үг.
- Мэргэшүүлэх хичээл 21 хичээл байгаа нь арай их биш үү? Яагаад ийм олон хичээл байдаг вэ? Тайлбарлана уу. Мэргэжлийн суурь хичээл нь сонгон хичээлд яваад байх шиг байна. Энэ тал дээр ямар бодолтой байна вэ? Тухайлбал заавал үзэх хичээлд ургамлын ангилалзүй байвал ямар байдаг вэ?
 - ◆ Тухайн суралцагчийн сонголтоор байдаг. Аль болох олон нэр төрөл байх нь тухайн суралцагчийг боломжоор хангана гэж үзэж байна. Зарим суралцагчид бакалаврын түвшинд үзчихдэг учраас өөр хөтөлбөрийн оюутнууд ангилалзүйн хичээлийг сонгодог. Үндсэн төгсөгчид нь өөр хичээлийг судлах боломжтой. Дараагийн хөтөлбөр шинэчилэлтээр ангилалзүйг оруулж өгөх боломжтой.
- Судалгааны аргагүй хичээл яагаад ийм өндөр кредиттэй байдаг вэ?
 - ◆ Энд тэнхимд суралцаж буй бүх оюутнууд суралдцаг.
- 2 болон 3 кредитийн ялгаа юу вэ?
 - ◆ Агуулган дээр суурилж байгаа.
- Төгсөгчдөөс хичээлийн тал дээр санал авдаг уу?
 - ◆ Авдаг. Судалгааны үр дүнг танилцуулав.
- Биоүйлдвэрлэл гэдэг нэр яагаад орсон бэ?
 - ◆ Ургамал тарималжуулалт хийдэг. Мөн саван, үнэртэн гэх мэт үйлдвэрлэл хийхийг л биоүйлдвэрлэл гэж үзэж байна. Нөхөн сэргээлтийн ажлуудыг мөн энэ чиглэлд хамруулж үзэж байна.
- 3.7 болон 3.8-д байгаа магистр хамгаалахад бүрдүүлэх материалууд нь магистр хамгаалах явцад оюутанд хир дарамт үүсгэдэг вэ?
 - ◆ Ихэнх материал нь сургалтын албанд байдаг учраас оюутанд үзүүлэх дарамт бага гэж үзэж байна.
- Бүтээлийн хуулбарлалт шалгадаг тогтолцоо байна уу?
 - ◆ Яригдаж байгаа. Одоогоор хэрэгжүүлээгүй байна.
- Судалгааны семинар гэдэг нь ямар критерээр /4 кредит/ тооцогддог вэ?

- ◆ Комисс томилдог. Явцынхаа ажлаар 2 удаа хэлэлцүүлдэг. Яг дүн шиг үнэлгээгээр явдаг. Мөн улсын хэмжээнд илтгэл хэлэлцүүлж байж хамгаалах эрх олж авдаг.
- 3.3.-д суралцагчдыг дэмжих тал дээр өөр ямар асуудлууд байх боломжтой вэ?
 - ◆ Магистрын эрдэм шинжилгээний хуралд түрүүлсэн магиструудад 2 сая төгрөгийн урамшуулал олгодог.
- Залуу судлаачдад грант олгох гээд тэтгэмж нь тогтмол байдаг уу?
 - ◆ Хавар болдог. Тогтмол олгогддог.
- Багшийн нөөц хангалттай байна. Багшийн үнэлгээ яаж явагддаг вэ? Урамшуулал гэх мэт..
 - ◆ Шилдэг судлаач багш, шилдэг сурган хүмүүжүүлэгч, шилдэг залуу багшийг 10 сард тодруулдаг. 21 оноос хойш IF сэтгүүлд өгүүлэл хэвлүүлвэл 1 сая төгрөгийн урамшуулал олгодог болсон.
 - ◆ Агроэкологийн сургууль багш нарын дунд ЭШХ зохион байгуулдаг.
 - ◆ А цаг 16 кр, Б цаг 9 кр байдаг. А цаг дээр 50%, Б цаг дээр 30% өгдөг.
- Адестатчлалыг хэзээ явуулдаг вэ?
 - ◆ 3 жил тутамд явагддаг. Үүгээр позишн нь хамаардаг.
 - ◆ Хичээлийн ачаал ихтэй, илүү цагийн 1 кр 130000 байдаг.
- 7.1-д дотоодын бусад их дээд сургуулиудын ижил хөтөлбөрүүдтэй яагаад харьцуулаагүй вэ?
 - ◆ Хөтөлбөрийн хэмжээнд байхгүй учраас харьцуулаагүй.
- Оюутнуудын тоо энэ хэвээр байх уу, нэмэгдүүлэх талаар ямар арга хэмжээ авах вэ?
 - ◆ Нэмэх талаар багш нарын зүгээс арга хэмжээ авч байгаа.
- Өөр чиглэлийн бакалаврыг ямар чиглэлд оруулж байгаа вэ?
 - ◆ 15 кр нэмж үзнэ. Холбогдох журмыг харах
- Өөрсдийн сэтгэгдэл ямар байна вэ? Багшийн ажиллах нөхцөл ямар вэ?
 - ◆ Орчин нөхцөлийг сайжруулах талаар шинэ байр луу нүүж байна.
 - ◆ Гербарийн сангийн өрөөг тусад нь гаргуулж өгөх саналтай байна.

II. Уулзалтанд оролцсон, одоо суралцаж байгаа магистрантуудын нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас	Оролцсон байдал
1	Г.Намуунбайгаль	I	Өмнөговь аймгийн Ноён сумын байгаль орчны улсын байцаагч, шинэ элсэгч	88636822	Онлайн
2	Д.Халиун	II	Оюу толгой ХХК-ын туслан гүйцэтгэгч Пиророда ХХК-ын нөхөн сэргээлтийн мэргэжилтэн, төгсөх курс	91133274	Танхим
3	М.Буянжаргал	II	Оюу толгой ХХК-ын туслан гүйцэтгэгч Пиророда ХХК-ын нөхөн сэргээлтийн мэргэжилтэн, төгсөх курс	89669905	Онлайн
4	Жавзандулам	II	Эрдэнэс Монгол ХК-ын тээвэр жуулчлалын газрын мэргэжилтэн	89944915	Онлайн
5	Н.Шижиртуяа	II	Хувиараа үйлдвэрлэл эрхэлдэг	89004551	Онлайн

Нийт 4 оюутан онлайн, 1 оюутан (Д.Халиун) танхимаар оролцов. Оюутнуудаас тодруулж ярилцах нь:

- Намуунбайгаль нь Эрдэнэс таван толгойг дүйцүүлэн хамгааллаар бакалаврын ажлаар хамгаалсан. Удирдагч багш нь П.Ариунсүрэн. Ашигт ургамлын нөөцийн чиглэлээр магистр хамгаалах зорилготой.

- Шижиртуяа нь 2011 онд элссэн. Хөвсгөл аймгийн Рашаант суманд амьдардаг. Тус газрын эмийн ургамлын нөөцийн чиглэлээр ажиллаж байна. Удирдагч П.Ариунсүрэн. Одоо хийж буй ажилд нь ургамлын судалгаа чухал болохоор сонгосон.
- М.Буянжаргал нь 2021 онд бакалавр хамгаалсан. Удирдагч Баярмаа. “Говийн бүсэд ховор ургамал тарималжуулалт” гэсэн сэдвээр бичиж байна.
- Жавзандулам нь 2020 онд төгссөн. Удирдагч Ариунсүрэн. Өмнөговь аймгийн нүүрс тээврийн компанид ажилладаг.
- Д.Халиун нь Бөхөгийн хөндийн түгээмэл тархалттай шороон ордод олон наст ургамал тариалж, бордооны нөлөө тодорхойлох. Удирдагч Х.Баярмаа.

Магистрантуудаас асууж тодруулсан зүйлс:

- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Яагаад энэ хөтөлбөрийг сонгосон бэ? Судалгаа шинжилгээний ажил хийхэд лаборатори, сургуулийн орчин, санхүүгийн байдлаар хир дэмжлэг үзүүлдэг вэ? Удирдагч багшийн сонголт хир байдаг вэ?
 - Намуунбайгаль: 5 хичээл судалсан. Өөрөө сонирхож судалсан учраас ургамлын мониторинг, ангилалзүй зэрэг хичээлүүд нь таалагдсан. Хээрийн судалгаанд оролцох боломжтой, лабоарторид оролцох боломжгүй
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг болон Доктор Ж.Энхтуул: 5 хичээл нь хэдэн кредит бэ? Ачаалтай байсан уу? 75% бие даалт, 25% лекц байдаг. Энэ нь хир вэ? Бие даалтыг яаж хийдэг вэ? Өгүүлэл уншдаг уу? Ном уншдаг уу?
 - Намуунбайгаль: 14 кр. Хүндрэлтэй байгаагүй. Хичээл судалсны дараа бие даалт хийдэг тул боломжийн байдаг. Бие даалтыг сэдвийн дагуу илтгэл, реферат хийдэг. Өгүүлэл уншиж хийдэг.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Бакалаврын хичээлтэй холбоотой юу? Хамгийн чухал хичээл нь юу байв?
 - Намуунбайгаль: Холбоотой. Ашигт ургамлын нөөц, мониторингийн хичээлүүд байсан.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Санал, хүсэлт байна уу?
 - Байхгүй. Багш нар бидний цаг завтай тааруулж хийдэг болохоор санал хүсэлт байхгүй.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Магистрын хөтөлбөрийн агуулга хир байна вэ?
 - Шижиртуяа: Хувиараа саван гоо сайхны бүтээгдэхүүн хийж эхэлсэн. Энэ бүхний суурь нь ургамал болсон учраас ургамлын талаар мэдлэг, хими биологийн онцлогийг судлах шаардлагатай болсон учраас магистраа үргэлжлүүлэн суралцаж байна.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Магистрын хичээлүүд нь өөрийн чинь сонирхож буй байдалд нийцэж байна уу?
 - Ургамлын хими талаас нь гүнзгийрүүлбэл зүгээр санагдаж байна.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Судалгааны ажлаа эхлүүлчихсэн байна уу? Ургамлаа сонгочихсон уу?
 - 40 гаран зүйлийн ургамал сонгосон. Тэдгээрийн байгалийн нөөцийг судалж байна. Тухайлбал ганга, цагаан уул, чацаргана гэх мэт.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Нөөцөө яаж тогтоож байна вэ? Нөөц тогтоосон ургамал байна уу? Судалгааны аргазүйгээ батлуулсан уу? Ургамлын цуглуулга хийдэг үү?
 - Байхгүй. Аргазүйгээ батлуулсан. Нөөц тогтоогоогүй. Цуглуулга хийгээгүй.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Хөтөлбөртэй холбоотой хэлэх зүйл байна уу?
 - Тэтгэлэг байдаг. Лаборатори, нарийвчилсан биойлдвэрлэлийн лаборатори зэрэг байхгүй.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Хийсэн бүтээгдэхүүнээ зарж үзсэн үү? Ямар бүтээгдэхүүн хийж үзсэн бэ?
 - Саван хийж зарж үзсэн.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Хамгаалахын тулд өгүүлэл бичих ёстой юу?

- 2 удаа семинар хийх шаардлагатай байдаг.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Буянжаргал эдгээр асуултуудад хариулна уу? Ямар ургамал дээр ажилладаг вэ? Аль нь сайн ургаж байна вэ?
 - Буянжаргал: Ямар нэгэн санал хүсэлт байхгүй ээ. Монгол мөнххаргана, *Halimodendron*, хойрго, *Caragana brachypodia* ургадаг. 2 ургамал нь 150, нэг нь 50 бодгаль байна. Харгана сайн ургаж байгаа.
- ❖ Доктор, профессор Б.Оюунцэцэг: Ямар ургамал тарималжуулж байна. Төлбөр яаж хийдэг вэ? Сургуулийн лабораторид ажилласан уу? Сургуульд дамжуулах санаа оноо юу вэ?
- ❖ Доктор Ж.Энхтуул: Био-үйлдвэрлэл гэхээр юу хийх вэ?
 - Бөхөгийн хөндийд нөхөн сэргээлт хийж байгаа. 2 зүйл - дагуурын өлөн, шар царгас гэсэн 2 зүйлийг тарималжуулж байна. 15%-ийн тэтгэлэг авсан, үлдсэн төлбөрийг өөрөө хийсэн. Хөрсний лабораторид хөрсний шинжилгээ хийсэн. Хичээлийн хувьд судлаачийн ёс зүй хичээлийг болиулж өөр хичээл орвол зүгээр санагдсан. Ургамлын ангилалзүй, ургамал тарималжуулалт, нутагшуулалт гэсэн хичээлүүд сонирхолтой байсан.
 - Хүлэмжинд ажиллаж байгаа нь нэг төрлийн биоүйлдвэрлэл гэж ойлгож байна.
 - Төлбөрийн хэмжээ боломжийн санагдаж байна.

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Осоржамаа	Газар Дэлхий компани	Захирал
2	Оюунцэцэг	Этүгэн их сургууль	Тэнхимийн эрхлэгч
3	Батчимэг	Дорнын Байгаль ХХК	Гүйцэтгэх захирал
4	Пүрэвсүрэн	Инженер геодеки ХХК	Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга
5	Адъяасүрэн	Дундговь аймгийн политехникийн коллеж	Багш

Шинжээчидийн зүгээс ажил олгогчдод тавьсан асуултууд:

- ★ Ажил олгогчдын зүгээс оюутнуудын мэдлэг, чадвар, хандлага ямар байгаа талаар
- ★ Цаашид сургууль, хөтөлбөр юун дээр анхаарвал сайн санагдаж байна?

1. Осоржамаа: Газар дэлхий компанийн захирал. Ажил олгогч нар төдийлөн ач холбогдол өгөхгүй байна. Мэргэжил суртачилах, оюутнуудад практик мэдлэг олгох тал дээр анхаарвал сайн. Хүүхдүүдийг мэргэжилд нь дурлуулах, хандлагыг өөрчлөх тал дээр сайн анхаараасай. Ирээдүйд энэ чиглэл чамаас хамаарна гэдгийн сайн ойлгуулж өгөөсэй гэж хүсч байна. Сэтгэлгээний чиг хандлага, тухайн компани миний гэр бүл гэдэг төлөвшил шаардлагатай байна. ХААИС-аас ургамлын чиглэлээр 2-3 оюутнууд ажиллаж байсан. Эзэмшсэн мэргэжил дээрээ хангалттай сайн биш. Шинэчилэлт хийх шаардлагатай. Хэлний мэдлэг муутай байдаг.

2. Оюунцэцэг: Этүгэн их сургуулийн тэнхимийн эрхлэгч, багш. Тус сургуулийн үндсэн төгсөгч. Ургамлын морфологи, физиологи, генетик зэрэг олон талын хичээл үздэг. Хичээлийн хөтөлбөрийн хувьд биоинженерчлэлтэй төстэй юмуу гэж хардаг. Ажил олгогчдын зүгээс төгсөгчидийн чадвар хангалттай. Мэргэжлийн хүмүүс ирдэг гэж хардаг. Манай сургуулийн шаардлагыг хангаж байна.

3. Батчимэг: Дорнын байгаль ХХК-ийн гүйцэтгэх захирал. Магистрант Мөнхтуул ажилладаг. Тус ангийг төгссөн магистр нь хээрийн судалгаанд сайн, ургамлаа сайн таньдаг, хянан баталгаа хийхдээ сайн байдаг. Sample point программыг эзэмшсэн. Түүн дээр судалгаагаа хийдэг. Шаардлага сайн хангадаг. GIS гүнзгийрүүлвэл сайн санагддаг. Төгсөгчдийн гадаад хэлний мэдлэг дунд, сайжруулах шаардлагатай. Ялангуяа яриа, бичгийн чадварыг сайжруулах шаардлагатай.

4. Пүрэвсүрэн: Инженер геодези Компанийн газар зохион байгуулалтын хэсгийн дарга. Хээрийн судалгаандаа сайн байдаг. Аймаг сумын бэлчээр тэжээлийн нөөц, бэлчээрийн даац зэргийг тооцож өгдөг давуу талтай. Манайх дадлага хийлгээд ажилд авдаг. GIS-ын хичээлүүдийг түлхүү оруулбал сайн байна. Санал: төслөөс гарсан мэргэжилтнүүдийг, хуучин төгсөгчид гэх мэт боловсон хүчнүүдийн чадвар мэдлэгийг сайжруулах, чадавхжуулах тал дээр хэсэгчилэн төлбөр төлөөд, хичээл судалдаг болбол их сайн байна.

5. Адъяасүрэн: Дундговь аймгийн Политехникийн коллежийн багш. Магистраа ойн чиглэл, ойн инженерээр төгссөн багш нар ажилладаг. Зөв хандлагатай, ажилдаа шаргуу, чадварлаг боловсон хүчнүүд байдаг. Хамтран ажиллах эхлэл тавигдсан. Ажил олгогчийн шаардлагыг хангасан төгсөгчид байдаг гэж үзэж байна. Хувь хүний төлөвшил, хариуцлагын тал дээр анхаарвал сайн санагддаг. Хэлний мэдлэг дундаж, цаашид сайжруулах шаардлагатай.

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Тунгалагбаяр	2014	Баян-Айраг суманд Компани	Нөхөн сэргээлтийн мэргэжилтэн
2	Баярмаа	2009	МАОЭШХ	ЭША
3	Мэндбаяр	2015	УЦУОШГ	Мэргэжилтэн
4	Соёлоо	2014	Батцэнгэл сумынЗДТГ	Мэргэжилтэн
5	Хишигжаргал	2012		
6	Төрбагана	2009	Уул урхайн компаин	Нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн
7	Болорцэцэг	2015	Этүгэн их сургууль	Багш
8	Лхагвасүрэн	2008	МАОЭШХ	Үр үржүүлэг, нөхөн сэргээлтийн мэргэжилтэн
9	Жавзандолгор		ХААИС	

Шинжээчдийн зүгээс тавьсан асуултууд:

- ★ Өөрсдийн танилцуулга
- ★ Хэзээ төгссөн
- ★ Хаана ажиллаж байгаа
- ★ Ямар сэдвээр хамгаалсан
- ★ Хөтөлбөрийн агуулгын давуу болон сул тал
- ★ Суралцаж байх үеийн орчин нөхцөл
- ★ Судалгаа явуулах боломж хэр байсан бэ?
- ★ Төгсөөд ажил олгогчдын шаардлагыг хангасан мэдлэг олж авсан уу?
- ★ Хөтөлбөрийг сайжруулах тал дээр санал байна уу?

1. Төрбагана: 2009 онд “Судан өвсний эрлийз сортыг Монголд нутагшуулах” сэдвээр хамгаалсан. Ногоон Алт төсөл, Тэжээлийн үр үйлдвэрлэгчдийн холбоо, Уул уурхайн компанид нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна. Оюутан байхаас судалгааны ажилд их хамрагдсан учраас ажил дээр гараад бэрхшээл хүндрэл байгаагүй. Төгссөний дараа багш нартайгаа нягт холбоотой байдаг учраас асуудал бага. Ажил олгогчдын сэтгэл ханамж сайн. Ажлын анкет өгөхөд эхний хоёр байранд л ордог. Давуу талтай гэж боддог. Хөтөлбөр сайжруулах тал дээр бодол алга. Магистрын хөтөлбөрийг Ургамлын нөөц, биоүйлдвэрлэл хөтөлбөрөөр төгссөн.
2. Баярмаа: Үндсэн төгсөгч. 2009 онд энэ хөтөлбөрөөр төгссөн. Оюутан цагаас Сэлэнгийн Шаамарт бэлчээрийн мониторингийн судалгаа хийж, “Татмын нугын алаг өвс-улаан толгойт бүлгэмдлийн бүтээмж” сэдвээр хамгаалсан. МААЭШХ-д ажилладаг. Хөтөлбөрийн агуулга дээр тухайн үед үр судлал, ургамлын физиологийн чиглэлийн хичээл нэмбэл зүгээр санагддаг. Англи хэл дээр мэргэжлийн хичээлүүдээ орвол зүгээр. Англи хэл дээрх бүтээлүүдтэй танилцаж байсан. Оюутан байхаас судалгаанд оролцож байсан учраас, төслийн хүрээнд хэлний мэдлэг сайжруулж байсан учраас ажилд ороход давуу талтай байсан.
3. Тунгалагбаяр: 2014 онд магистраа “Шарын голын нүүрсний уурхайн хөрс, ургамлан нөмрөг” сэдвээр магистр хамгаалсан. 2018 оноос Баян-Айрагт компанид нөхөн сэргээлтийн чиглэлээр ажиллаж байна. Манайх практик тал дээр сайн санагддаг. Үр судлал, генетикийн чиглэлийн хичээлүүд орвол зүгээр санагддаг. Ажил дээр гарсны дараа асуудал үүсээгүй. Бэлчээрийн судалгааны суурь сайтай байсан учраас. Лабораторид суух тал дээр дутагдалтай байсан.
4. Болорцэцэг: 2015 онд “Сибирь хялганы ган болон давсны сртесс тэсвэржилт” сэдвээр магистр хамгаалсан. Оюутан ахуй цагаас зүлэгжүүлэлт, бэлчээрийн судалгаануудад оролцож байсан. Этүгэн их сургуульд ургамал судлал, эмийн ургамал сэдвүүдээр ургамлын багшаар ажиллаж байна. Үрийн чанар, хадгалалт зэргээр үрийн биологийн хичээл орвол зүгээр санагдсан. Эмийн ургамлын чиглэлээр нарийвчлан ажиллах төлөвлөгөөтэй байна.
5. Лхагвасүрэн: Үндсэн төгсөгч бус. 2008 онд “Орхон голын сав газрын ургамалжилтын судалгаа” сэдвээр магистр хамгаалсан. БОАЖЯ, Jaica зэрэг олон улсын төслүүдэд туслах судлаачаар, Ногоон алт төсөлд тэжээлийн олон наст ургамлын үрийн чиглэлээр, МААЭШХ-ийн Бэлчээр тэжээлийн салбарт үр үржүүлэг, нөхөн сэргээлтийн чиглэлээр байна. Дадлагын ажил 1-2 удаа богино хугацаагаар хийгдсэн байдгийг урт хугацаатай болгож, практик мэдлэгийг нэмэгдүүлвэл зүгээр. Орчин үед нийцүүлээд лабораторийн нарийн судалгаанууд хийвэл сайн. Хэлний мэдлэг нэмэгдүүлэх тал дээр анхаарвал сайн. Ургамал таних зэрэг дээр давуу талтай байсан.
6. Мэндбаяр: 2015 онд “Ургамлын газрын дээрх ба доорх биомассын харьцаанд бэлчээрийн талхлагдал ба хөрсний зарим шинж чанарын нөлөөлөл” сэдвээр магистр хамгаалсан. Энэ чиглэлээр үргэлжлүүлэн докторт суралцаж байна. АХБ-ны төсөл, УЦУОШГ-т ажиллаж байна. Мэргэжлийн хичээлүүд маш сайн ордог. Англи хэлний хичээлийн цагийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Математик, статистикийн хичээлүүд орвол зүгээр. Зайнаас тандан судлалын хичээлүүдийг орвол зүгээр. Боловсон хүчин цөөхөн бэлтгэгдээд байгаа тул мэргэжил суртачилах тал дээр анхаарвал сайн.
7. Соёлоо: 2014 онд магистр хамгаалсан. Батцэнгэл сумын Тамгын газарт ажилладаг. Мэргэжилдээ сэтгэл хангалуун байна. Хээрийн судалгаа, ургамлын тал дээр асуудалгүй сайн байдаг. Статистик, зайнаас тандангийн хичээлүүдийг нэмэгдүүлж өгвөл сайн.
8. Хишигжаргал: 2012 онд “Цөлөрхөг хээрийн бүсэд зарим зүйл ургамлыг тарих боломж” сэдвээр магистр хамгаалсан. Ургамлын экологи, эдийн засгийн үнэлгээний чиглэлээр хичээл орвол сайн. Статистикийн хичээлийг оруулах

шаардлагатай. Бусад сургуулиудтай харьцуулахад практик талдаа сайн. Лабораторийн судалгааны ажлуудыг нэмэгдүүлбэл сайн.

9. Жавзандорж: Нөхөн сэргээлтийн чиглэлээр магистр хамгаалсан. ХААИС-д ажилладаг. Цэцэрлэгжүүлэлтийн талаад хичээл дадлагаар оруулж өгвөл сайн. Хэлний хичээлийг оруулж өгвөл сайн.

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/


ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
ИННОВАЦЫН ГАЗАР
17029 Улаанбаатар хот, Хая-Уул дүүрэг, 22 дугаар хороо,
Зайсан 5, Утас: 7310 7777 410
Э-суудал: agri_science@msu.edu.mn, www.msu.edu.mn
2023-05-10 № 1/06
талбай _____ -ны № _____ -г
Боловсролын магадлан итгэмжлэх
үндэсний зөвлөлд

ХААИС-ийн магистрын Ургамлын нөөц, био-
үйлдвэрлэл (081114) хөтөлбөрийн магадлан
итгэмжлэх шинжээчийн багийн үнэлгээний
тайлантай танилцлаа. Бид шинжээчийн багийн
гишүүдээс ирүүлсэн санал зөвлөмжийг хэрэгжүүлж
ажиллах болно.


ЗАХИРАЛ
ШИНЖИЛГЭЭ,
ИННОВАЦЫН
ГАЗАР
Б.МӨНХБАТ

D: Documents of MULS/2023/ Sent A5

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа